



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Гадаадад томилолтоор ажиллуулах тухай

Нийслэлийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.10 дахь заалтын хүрээнд Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот, ОХУ-ын Сургуулийн сагсан бөмбөгийн лиг "КЭС-Баскет" байгууллагын хооронд байгуулсан хэлэлцээр, Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын ахлах мэргэжилтэн А.Болдмаа, мэргэжилтэн Ж.Ганзориг нарыг ОХУ-ын Москва хотноо 2014 оны 04 дүгээр сарын 03-16-ны өдрүүдэд болох ерөнхий боловсролын сургуулийн "Сурагчдын лиг" сагсан бөмбөгийн олон улсын шигшээ тэмцээнд оролцуулсугай.

2. А.Болдмаа, Ж.Ганзориг нарын энэхүү арга хэмжээнд оролцох ажлын удирдамжийг нэгдүгээр, шаардагдах зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. А.Болдмаа, Ж.Ганзориг нарын Москва явах зардалд 5.728.000 /таван сая долоон зуун хорин найман мянга/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын орон нутгийн төсвийн арга хэмжээний зардлаас гаргахыг ня-бо О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.

4. Арга хэмжээнд оролцсон тайлан, зардлын тооцоог ирснээс хойш, ажлын 3 хоногт багтаан тайлагнахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Tushaal 2014

1150500053

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2014 оны дөрөвдүгээр сарын 9-ний өдрийн
...тоот тушаалын нэгдүгээр хавсралт


Ахлах мэргэжилтэн А.Болдмаа,
мэргэжилтэн Ж.Ганзориг нарын
ОХУ-ын Москва хотод ажиллах удирдамж

Нийслэлийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.10 дахь заалтын хүрээнд Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот, ОХУ-ын Сургуулийн сагсан бөмбөгийн лиг "КЭС-Баскет" байгууллагын хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу:

- 2014 оны 04 дүгээр сарын 03-16-ны өдрүүдэд болох ерөнхий боловсролын сургуулийн "Сурагчдын лиг" сагсан бөмбөгийн Олон улсын шигшээ тэмцээнд оролцох баг тамирчдын ахлагчаар ажиллах,

- Дээрхи шигшээ тэмцээнд оролцох эрх авсан Багануур дүүргийн "Боловсрол" цогцолбор сургуулийн охидын багийн, Хан-Уул дүүргийн 52-р сургуулийн хөвгүүдийн багийн тамирчдыг энэхүү нэр хүндтэй тэмцээнд зохион байгуулалт сайтай оролцуулах,

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2014 оны дөрөвдүгээр сарын 01-ний өдрийн
1/24 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



Ерөнхий боловсролын сургуулийн
сагсан бөмбөгийн “Сурагчдын лиг”
олон улсын шигшээ тэмцээнд
оролцох зардлын төсөв

№	Зардлын нэр	Дүн /төг/
1.	Унааны зардал: УБ – Москва – УБ /1.440.000 төг х 2 = 2.880.000 төг/	2.880.000
2.	Визийн хураамж: 2 хүн х 80 ам.долл х 1800 ₮ = 288.000 төг	288.000
3.	Бэлэг дурсгалд: /400.000/	400.000
4.	Томилолтын зардалд: /120 ам.дол х 2 хүн х 5 хоног = 1200 ам.долл х 1800 ₮ = 2.160.000 төг/	2.160.000
НИЙТ ДҮН:		5.728.000